



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/33

Номгон

「Бүх нийтийн эрх зүйн боловсролыг 2025 онд
дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/27 дугаар “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолын 151 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг 2025 онд дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 3.000.000 (Гурван сая) төгрөгийг аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

625010167

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын
24-ний өдрийн 4/36 дугаар захирамжийн
хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв мянга/төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах байгуулл ага
				он	Түвшин			
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт Нэг. Үндсэн хуулийг сурталчлах ажлын хүрээнд								
1.1.	Монгол Улсын Үндсэн хуулийг аймгийн хэмжээнд сурталчлан ажиллах эрх бүхий сургагч багш нартай хамтран иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	-Сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо -Оролцогчдын тоо -Мэдлэг сайжралтын хувь	2024	-	2 200 80 хувь	2025.01.08- 2025.12.15	Хууль, эрх зүйн хэлтэс
1.2.	Монгол Улсын үндсэн батлагдсан өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах	-	Хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ, сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо	2024	1	1 1	2025.01.13- 2025.01.15	Хууль, эрх зүйн хэлтэс
Зорилт Хоёр. Иргэд, төрийн албан хаагчдад эрх зүйн боловсрол олгох ажлын хүрээнд								
2.1.	Эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах танхимын болон цахим сургалтыг зохион байгуулах	2.0 сая/төг	Цахим сургалт-10 Танхимын сургалт-1	2023	45	50	2025.02.01- 2025.11.15	Хууль, эрх зүйн хэлтэс
2.2.	Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг 7 хуулийн хүрээнд зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо Мэдлэг сайжралтын хувь	2024	5506	5600 50 хувь	2025.02.20- 2025.12.15	Хууль, эрх зүйн хэлтэс

1	2	3	4	5	6	7	8	9
2.3.	Сум, байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат сургалтыг тухай бүр зохион байгуулах	-	-Захиалга өгсөн сум байгууллагын тоо -Сургалтад оролцсон иргэд, ТАХ, сум, байгууллагын тоо -Мэдлэг сайжралтын хувь	2024	59	20 1000 50 хувь	2025.01.22- 2025.12.08	Хууль, эрх зүйн хэлтэс
Зорилт Гурав. Нийгмийн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах ажлын хүрээнд								
3.1.	"Хуулиа дээдлэгч байгууллага" арга хэмжээний хүрээнд сум, байгууллагуудын эрх зүйн ажлыг сайжруулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Хуулиа дээдэлье" болзолт уралдааныг зохион байгуулж үр дүнг тооцох	1.0 сая/төг	Уралдааныг зохион байгуулж урамшуулсан байгууллагын тоогоор	2024	3	3	2025.02.01- 2025.12.01	Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцаху йн төв
3.2.	Иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгож, үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгөх хуульчийн Про боно өдөрлөгийг зохион байгуулах	-	Өдөрлөгийн зохион байгуулснаар тоо, хувиар	2024	1 100%	1 100%	2025.04.01- 2025.12.31	Хууль, эрх зүйн хэлтэс
3.3.	"Хуулиа дээдлэгч гэр бүл" арга хэмжээг 20 суманд зохион байгуулах	-	-Гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулсан тоо -Оролцогч гэр бүлийн тоо	2024	-	20 250	2025.04.01- 2025.12.31	Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцаху йн төв
3.4.	"Хуулиа дээдлэгч иргэн" арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгүүдрүү чиглэсэн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	-Танхимын болон цахим сургалтын тоо -Сургалтад оролцогчдын тоо	2024	-	3 3 300	2025.02.02- 2025.11.15	Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцаху йн төв

1	2	3	4	5	6	7	8	9
3.5.	“Хуулиа дээдлэгч хүүхэд” арга хэмжээний хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	-Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд оролцогчдын тоо -Бүтээлийн тоо	2024	-	500 10	2025.02.02- 2025.11.15	Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв
3.6.	Хууль тогтоомжийг сурталчлах хянан шалгах, зөвлөн туслах ажлыг зарим сумдад зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан иргэд ТАХ-ын тоо Мэдлэг нэмэгдсэн хувь Түгээсэн гарын авлага, цахим постер, шторкны тоо Хандалтын тоо	2024	20 сум	2 сум 1600 50 хувь	2025.02.01 2025.10.30	Хууль, эрх зүйн хэлтэс
3.7.	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	-	Соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо	2024	0	5	2025.02.02- 2025.11.15	Хууль, эрх зүйн хэлтэс
3.8.	Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх	-	Дүн шинжилгээ хийхэд хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийн тоо	2024	0	1	2025.02.02- 2025.11.15	Хууль, эрх зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар
3.9.	Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын хүрээнд холбогдох төрийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх	-	Хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	2024	0	2	2025.02.15- 2025.11.10	Хууль, эрх зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар